

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ, ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН
АЖИЛЛАХ ХЭЛБЭР**

НЦГ-ын ОНХХ-ийн чиглэлийн ахлах байцаагч,
цагдаагийн хошууч А.Отгонбаяр

Цагдаагийн байгууллагын тогтолцоо

Зохион байгуулалтын зарчим :

- ▣ Нутаг дэвсгэрийн /аймаг нийслэлийн цагдаагийн газар,хэлтэс, сум, дүүргийн буюу сум дүүрэг дундын хэлтэс,тасаг, хэсэг/
- ▣ Ажил үүргийн /хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, эрүүгийн болон замын, хэв журмын гэх мэт/






Удирдлагын зарчим :

- ▣ Нэгдмэл төвлөрсөн /ЗГ-ХЗДХЯ-**ЦЕГ**/
- ▣ Нутаг дэвсгэрийн удирдлага /ИТХ-тэргүүлэгчид-Засаг дарга/

Санхүүжилт :

- ▣ Улсын төсөв

ЦБ



- ▣ Төр хил хязгаарын дотор засаглах чиг үүргийг хэрэгжүүлдэг
- ▣ Татвараар санхүүжиж, иргэдэд хандсан үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлдэг
- ▣ Үүрэг нь ГЯТ, НХЖХ, НАБХ
- ▣ Тодорхой хууль, дүрэм журам, стандарттай
- ▣ Онцлог нь хуульд заасан нөхцөлд эрх хязгаарлах, албадлага хэргэлдэг



Хүч-
ний

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮҮРЭГ



Гэмт хэрэгтэй
ТЭМЦЭХ



▣ Нийгмийн хэв
журам
хамгаалах

Гэмт хэрэгтэй тэмцэх гэдэг нь :

- ▣ Урьдчилан сэргийлэх
- ▣ Таслан зогсоох
- ▣ Шуурхай илрүүлэх гэсэн 3 чиглэлтэй.

- ▣ Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулна.

Зорилтыг хэрхэн эрэмблэхээс шалтгаална



Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа :

- ▣ Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судалж тогтооход чиглэсэн **цогц** үйл ажиллагаа бөгөөд ГХТҮА-ны гол суурь ойлголт.
- ▣ **Бололцооны хүрээнд:** Гэмт хэргийн талаархи мэдээллийг цуглуулж, судалгаа, дүн шинжилгээ хийх замаар түүний гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхээр хуульчилсан
- ▣ **Бодит байдлын хүрээнд:** Судалгааны иж бүрэн тогтолцоо байхгүй
/Мэдээлэл судалгааны төв, хэсгийн байцаагч нарын судалгаа, сар улирал, жилийн статистик мэдээ г.м/

Төрөл нь:

- ▣ Ерөнхий буюу зохион байгуулалтын шинж чанартай нийтлэг арга хэмжээ /Төр засаг/
- ▣ Тусгай буюу тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгахад чиглэсэн арга хэмжээ /Нийтлэг/
- ▣ Нэг бүрчилсэн буюу тодорхой этгээдэд чиглэсэн арга хэмжээ /Тодорхой хүрээнд/

- ▣ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд шалтгаан, нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлс, үйлдэгдэж буй нутаг дэвсгэр, цаг хугацаа, **объект, субъект**, эрүү, хэв журмын нөхцөл байдал зэрэгт судалгаа хийнэ.
- ▣ Энэ судалгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах ЦБ-ын үндсэн үүрэг, зорилтыг ханган биелүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагааны суурь болдог.

Статистик
мэдээ

Объектив,
субъектив судалгаа

Судалгаа

Тойм, тоон
мэдээ,
танилцуулга

Нөхцөл
байдлын
судалгаа /Улс
төр, эдийн засаг,
нийгэм, цаг
үеийн шинжтэй
хүчин зүйлс/

Судалгааны үр дүн, ач холбогдол

- ▣ Нөхцөл байдлын талаар бодит дүр зураг бий болно.
- ▣ Үйл ажиллагааны зохион байгуулалт, оновчтой хэлбэрт шилжинэ. /Эргүүлийн чиглэл гэх мэт/
- ▣ Албад хоорондын ажлын уялдаа, холбоо сайжирна. /Дотоод, гадаад хүрээнд/
- ▣ Арга хэмжээг тодорхой үндэслэл, зорилготойгоор явуулна.
- ▣ Удирдлага, менежментийн үйл ажиллаганы түвшин дээшилнэ.


Шуурхай таслан зогсоох үйл ажиллагаа гэдэг нь :

- ▣ “ Гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж, үйлдэж байгаа талаар мэдээлэл авмагц таслан зогсоож, учирч болох хор хохиролыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байхад чиглэсэн **шуурхай** үйл ажиллагаа”
- ▣ **ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧИЛ НЭГ БҮРИЙГ БҮРТГЭЖ БАЙХ** / мэдээ мэдээллийг өргөн сувгаар авч байх, мэдээлэл нэг бүрт ач холбогдол өгч, мэдээлэл хүлээн авах тогтолцоо, арга хэлбэрийг өөрчлөх-иргэдийн ухамсар, урамшуулал гэх мэт/
- ▣ **ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ НЭГ БҮРТ ХҮРЧ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ**
/эргүүлийн үйл ажиллагааны оновчтой зөв хэлбэрийг бий болгож, эргүүл- хяналтын бусад хэлбэрийг нэвтрүүлэх, жнь:-телекамер/

Бүрэн илрүүлэх үйл ажиллагаа ГЭДЭГ НЬ :

- ▣ “ЦБ гэмт хэрэг үйлдэгдсэн тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоон, түүний үйлдэл нэг бүрийг **шуурхай, бүрэн** илрүүлэх арга хэмжээ юм”
- ▣ Урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлын чанар, үр дүнгээс гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагаа **шууд** хамаардаг.

Илрүүлэх



Шуурхай
илрүүлэх

Урьдчилан
сэргийлэх

Таслан
зогсоох

Илрүүлэх

Илрүүлэх

Таслан
зогсоох

Урьдчилан
сэргийлэх

Гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагаа нь агуулгын хувьд :

- ▣ Үйлдэгдсэн тодорхой гэмт хэрэг нэг бүрийг илрүүлэх /Урьд өмнө нь цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй буюу бугшмал гэмт хэрэг/
- ▣ Гэмт хэрэг үйлдсэн хүн нэг бүрийг олж тогтоох
- ▣ /Бүртгэгдэх үедээ сэжигтэн тогтоогдоогүй гэмт хэрэг/
/Эдгээрийн нийтлэгээр нь “эзэнгүй гэмт хэрэг” гэсэн ойлголтонд хамруулдаг/

Нийгмийн хэв журам хамгаалах гэдэг нь :

- ▣ ЦБ-нь гудамж талбай олон нийтийн газар хууль тогтоомжоор болон төрийн эрх бүхий бусад байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмыг сахиулж, хүн амын амгалан тайван байдлыг хамгаалах үйл ажиллагаа.
- ▣ **НХЖХ** чиг үүргийн хүрээнд хуулиар харьяалуулсан захиргааны зөрчлийг шалгаж шийдвэрлэнэ.

ЦБ-ын бусад чиг үүрэг :

- ▣ Гэмт хэрэг үйлдсэн этгээд, алдагдсан эд зүйлийг эрэн сурвалжилж олох, гэмт хэргийг илрүүлэх таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах
- ▣ Шинжилгээ хийж дүгнэлт гаргах
- ▣ Цагдан хорих, баривчлах, албадан саатуулах шийдвэрийг биелүүлэх
- ▣ Ял эдлүүлэх тогтоолыг биелүүлэх
- ▣ Эрүүлжүүлэх
- ▣ Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах
- ▣ Захиргааны шинжтэй бусад чиг үүрэг

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг, оролцоо гэдэг нь нэг талаас хамтран ажиллах, нөгөөтэйгүүр бэрхшээлтэй асуудлыг хамтран шийдвэрлэх арга замын тухай асуудал юм.



Үүрэг?

Оролцоо
?

▣ Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаан дахь хэвлэл мэдээллийн байгууллагын эрх, үүргийг:

- a) Ёс зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан
- b) Эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан гэж ангилж үзэж болох юм.

Нөгөө талаар **эрх, үүрэг, хариуцлага нь** харилцан хамаарал бүхий цогц байдлаар агуулгаа тодорхойлж, хэрэгжин биелэх баталгаа нөхцлөө тодотгож байдаг. Энэ утгаараа хариуцлага нь :

- a) Ёс зүйн хариуцлага
- b) Эрх зүйн хариуцлага гэсэн ангилалатай байна.

Хэвлэл мэдээллийн байгууллагын эрх үүрэг нь :

- ▣ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь гэмт хэргийн тухай мэдээлэл хийхдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан нөхцөл хор холбогдлыг олон нийтэд таниулах, сэрэмжлүүлэхийг гол зорилго болгоно.
- ▣ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр яаралтай нийтэлж нэвтрүүлнэ.
- ▣ Төрийн өмчийнхөөс бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр яаралтай мэдээлэл, нийтлэл нэвтрүүлсний төлбөрийг тухайн байгууллага хариуцана.
- ▣ Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, аллага, хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлсэн, сурталчилсан, үйлдэх аргыг нарывчлан харуулсан нийтлэл нэвтрүүлэг хийхийг хориглоно.
- ▣ Шүүхээр гэмт буруутай нь нотлогдоогүй байхад хэнийг ч гэмт буруутай гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно.

Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо

- ▣ Хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх дараах арга, хэлбэрүүд байж болох юм. Үүнд :
 - Хэвлэл мэдээллийн байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх ажилд татан оролцуулах эдийн засгын боломжийг бүрдүүлэх /энэ нь төсвөөс мөнгө хувиарлаад бай гэсэн үг биш бөгөөд судалгаанд тулгуурлан, оролцооны үр дүнтэй хэлбэрийг урамшуулах арга юм/
 - Хэвлэл мэдээллийн байгууллагуудыг гэмт хэрэгтэй тэмцэх ажилд зохион байгуулж оролцуулан, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах

Үргэлжлэл :

- Хэвлэл мэдээлэл гэж юу болохыг таньж мэдэх, түүний төрөлд хамаарах бүтцүүдийг судлан, төрөл бүрт тохирсон арга, аргачлалыг сонгох
- Хууль сахиулах ажиллагааны үед хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагаа, эрх ашгийг хүндэтгэх
- Хэвлэл мэдээллийнхэн шаардлагатай байгаа орон зайг судлах
- Хэвлэл мэдээллийн байгууллага, ажилтнуудаар гүйцэтгүүлж болох үйл ажиллагааг тэднээр гүйцэтгүүлэх боломж, нөхцлийг бүрдүүлэх



Үргэлжлэл :

Эрх үүрэг

Оролцоо

Хамтын ажиллагааны хэлбэрийг зөв тодорхойлж, хэрэгжих боломж арга замыг бий болгох нь гол зорилт

